



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2015/06



pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ**

(2015 оны 6 дугаар сарын байдлаар)

Нэг. Нийгмийн үзүүлэлт**1.1 Хүн ам**

Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2015 оны эхний 6 сард 795 хүүхэд шинээр мэндэлж, 144 хүн нас баржээ. Хүн амын цэвэр өсөлт 651 болж 2014 оны мөн үеийнхээс 19.7 хувиар буюу 107-оор нэмэгдлээ. 1000 хүнд ногдох төрөлт 12.4, нас баралт 2.3 байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад төрөлт 0.6 пунктээр нэмэгдэж, нас баралт 0.9 пунктээр буурсан байна.

Зураг. Төрсөн хүүхэд, нас барсан хүний тоо. 2011-2015 оны эхний 6 сард



Он гарсаар эхийн эндэгдэл гараагүй бөгөөд амьд төрсөн 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдэл 12.6 байгаа нь өмнөх оны мөн үеэс 2.4 пунктээр хасагдсан байна.

**1.2 Бүртгэлтэй ажилгүй иргэн**

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэд 2015 оны 6 сард 1451 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 26.1 хувиар өсж, 2014 оны жилийн эцсийн дүнгээс 0,1 хувиар буурсан байна. Бүртгэлтэй ажилгүй иргэдийн 833 буюу 57,4 хувийг эмэгтэйчүүд эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 4,7 пунктээр буурчээ. Мөн бүртгэлтэй ажилгүй иргэдийн боловсролын түвшинг харахад 34.7 хувь нь бүрэн дунд, 26,8 хувь нь дээд, 13.1 хувь нь бүрэн бус дунд, 11.5 хувь нь тусгай дунд, 9.2 хувь нь техник болон мэргэжлийн, 3,4 хувь нь бага, 0,9 хувь нь боловсролгүй, 0.3 хувь нь магистр/ докторын боловсролтой иргэд тус тус эзэлж байна.

Хөдөлмөрийн хэлтэст ирсэн 118 ажлын байрны захиалгын 49,2 хувь нь үйлчилгээний бусад үйл ажиллагаа, 22,9 хувь нь боловсруулах үйлдвэрлэл, 27,9 хувь нь бусад салбарын захиалга эзэлж байна.

Ажлын байрны захиалгыг ажил, мэргэжлийн ангиллаар нь авч үзвэл 44,9 хувийг энгийн ажил мэргэжил, 36,4 хувийг техник болон туслах дэд мэргэжилтэн, 18,7 хувь нь бусад ажил мэргэжил эзэлж байна. Ажилгүй 389 иргэн ажилд зуучлагдан орсоны 54,8 хувь нь эмэгтэйчүүд байна. Аймгийн дүнгээр 353 шинэ ажлын байр бий болгожээ. Ажилд орсон иргэд 100 хувь байнгын ажлын байртай болжээ.

pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.


Get yours now!



1.3 Нийгмийн даатгал, халамж

2015 оны эхний 6 сард нийгмийн даатгалын санд 10 728.6 сая төгрөгийн орлого төвлөрсөн нь өмнөх оны мөн үеэс 5.3 хувиар буурсан байна.


Зураг. Нийгмийн даатгалын сангийн орлого сангийн төрлөөр /сая.төг/ 2015 оны 6 сард



Тэтгэврийн даатгалын сангаас 11 462.9 сая.төг, тэтгэмжийн даатгалын сангаас 929.0 сая.төг, эрүүл мэндийн даатгалын сангаас 1704.6 сая.төг, ҮОМШӨ-ний даатгалын сангаас 673.8 сая. төг, ажилгүйдлийн даатгалын сангаас 217.2 сая.төг, нийт 14 987.5 сая.төгрөгийг зарцуулжээ.

Оны эхний 6 сард нийгмийн халамжийн сангаас 11 844 иргэнд 2,571,8 сая төгрөгийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж олгожээ. Жирэмсэн болон хөхүүл хүүхэдтэй 1720 эхэд 365,0 сая төгрөгийг улсын төсвөөс олгосон байна. Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн дагуу 2405 иргэнийг нэг удаагийн тусламж үйлчилгээнд хамруулсан нь өмнөх оны мөн үеэс 0,3 хувиар өссөн байна.

Зураг. Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр тэтгэмжийн хэмжээ /төрлөөр/, 2015 оны эхний 6 сард





1.4 Эрүүл мэнд

Он гарсаар 199,4 мянган хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 8.3 хувиар, 7,2 мянган хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар буурч, урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдсан хүний тоо 6.1 мянга байгаа нь өмнөх оны мөн үеэс 1,7 хувиар өссөн байна.

Эхний 6 сард 859 эх жирэмсний хяналтанд орсны 83.2 хувь буюу 715 эх жирэмсний эхний 3-н сард хяналтанд хамрагджээ.

Түргэн тусламжийн дуудлага 9,8 мянган удаа гарсны 1,6 мянга буюу 16.3 хувь нь алсын дуудлага байв. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал нийт түргэн тусламжийн дуудлага 14.8 хувиар, алсын дуудлага 15.8 хувиар буурлаа.

Он гарсаар ослын улмаас 1297 хүн бэртэж, 35 иргэний амь нас энджээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулбал ослын улмаас бэртсэн хүний тоо 18,9 хувиар нэмэгдэж, нас барсан хүний тоо 21-ээр буурсан байна.

Халдварт өвчний 524 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 25-аар буюу 4,6 хувиар буурчээ.



5 Соёл

Аймгийн музейнүүд 6 сарын байдлаар дотоод, гадаадын 2.7 мянган хүнд үйлчилж 3,0 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.



1.5 Байгаль орчин

Цаг уур

2015 оны 6 дугаар сард нийт нутгаар агаарын дундаж температур өдөртөө 20.0 хэм дулаан, шөнөдөө агаарын температур 4-8 хэм хүйтэн, өдөртөө 31-35 хэм дулаан байлаа. Хөрсний гадарга дээр шөнөдөө 1-6 хэм хүйтэн, өдөртөө 51-61 хэм дулаан, дунджаар 27 хэм дулаан байв. Энэ сард нийт нутгаар 1.1-37.5 мм хур тунадас орлоо. Орсон хур тунадасны нийлбэрийг ОЖД-тай харьцуулахад Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, сумдад олон жилийн дундажаас бага, бусад сумдын нутгаар олон жилийн дундажаас ахиу байлаа. Энэ сард хамгийн их хур тунадас Хатанбулаг суманд 37,5 мм, Улаанбадрах суманд 31,4 мм Өргөн суманд 26,3 мм Хөвсгөл суманд 25,1 мм Сайншанд суманд 24,6 мм, Сайхандулаан суманд 22,0 мм, Мандах суманд 19,9 мм, Замын-Үүд суманд 19,8 мм, Эрдэнэ суманд 19,5 мм орж, Айраг, Алтанширээ Дэлгэрэх, Иххэт сумдад хамгийн бага 1,1-9,2 мм хур тунадас орлоо. Нийт нутгаар хур тунадастай өдөр байлаа.



1.6 Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн мэдээгээр оны эхний 6 сард 295 хэрэг бүртгэгдэж, гэмт хэргийн улмаас 21 хүн нас барж, 120 хүн гэмтэж бэртсэн байна. Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс 8,5 хувь буюу 23-аар нэмэгдсэн байна.

Хэргийн төрлөөр үзвэл өмнөх оны мөн үеэс иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэргүүд нэмэгдлээ.



Нийт бүртгэгдсэн гэмт хэргийн 32.5 хувийг иргэдийн эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг, 28.5 хувийг өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, 13.6 хувийг тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 25,4 хувийг бусад төрлийн гэмт хэргүүд эзэлж байна. Нийт гэмт хэргийн 33.2 хувь буюу 98 нь согтуугаар үйлдэгдсэн байна.

Гэмт хэргийн тоо өмнөх оны мөн үеэс Даланжаргалан, Мандах, Өргөн Улаанбадрах, Хөвсгөл сумдад буурч, Айраг, Алтанширээ, Дэлгэрэх, Иххэт, Сайхандулаан, Хатанбулаг, Өргөн сумдад адил хэмжээнд, Алтанширээ, Иххэт, Сайхандулаан, Хатанбулаг, Эрдэнэ, Сайншанд, Замын-Үүд сумдад нэмэгдлээ. Гэмт хэргийн улмаас иргэд, байгууллага, аж ахуйн нэгжид 425,6 сая төгрөгийн хохирол учирсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад 332,0 сая төгрөгөөр буюу 56.9 хувиар буурсан байна. Учирсан хохирлын 79,2 хувь буюу 337,1 сая төгрөг эргэн төлөгдсөн байна.

Нийт гэмт хэргийн 33.2 хувийг согтуугаар, 33.2 хувийг гэр сууцандаа, 19,7 хувийг гудамж олон нийтийн газарт, 7,5 хувийг бүлэглэн, 12.5 хувийг эмэгтэй хүн, хүүхэд оролцон, 53,9 хувийг шөнө, оройн цагаар /19-22, 22-06 цаг/ үйлдсэн байна. Тайлант хугацаанд нийт 794 хүн саатуулагдаж, 202 хүн баривчлагджээ.

Хоёр. Эдийн засгийн үзүүлэлт



2.1 Төрийн санхүү

2015 оны 5 сарын дүнгээр орон нутгийн төсөвт 16687.4 сая төгрөгийн орлого төвлөрүүлжээ. Орон нутгийн төсвийн орлогын 31.2 хувийг татварын, 68.8 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна. Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт 83.7 хувьтай байна.

Улсын нэгдсэн төсөвт 2015 оны эхний 6 сарын байдлаар ААНБ-ын орлогын албан татвар, дотоодын бараа, үйлчилгээний татвар, ашигт малтмал нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр, өсөн нэмэгдэх ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр нийт 1329.9 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөг 8.7 хувиар давуулан биелүүллээ.



2.2 Мөнгө, банк


Монгол банкны мэдээгээр арилжааны банкуудын кассын орлого 652.7 тэрбум төгрөг болж өмнөх оноос 29.3 хувь, цэвэр зарлага 610.7 тэрбум төгрөг болж 24.7 хувиар буурчээ.

Иргэдийн мөнгөн хадгаламж 44.7 тэрбум төгрөг болж нэг хадгаламж эзэмшигчдэд дундажаар 669.4 мянган төгрөг, аймгийн нэг хүнд дундажаар 704.7 мянган төгрөгийн хадгаламж ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хадгаламж эзэмшигчийн тоо 1.9 хувиар буурч, хадгаламжийн үлдэгдэл 6 хувиар өссөн байна.


Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зээлийн өрийн үлдэгдэл 2.8 хувиар буурч, хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэл 80,9 хувиар, чанаргүй зээлийн үлдэгдэл 64.5 хувиар нэмэгджээ.



Зураг. Хадгаламж эзэмшигч, зээлдэгчийн тоо, 2014- 2015 он, мян.хүн



Зураг. Хадгаламжийн үлдэгдэл, зээлийн өрийн үлдэгдэл, 2014-2015 он, сая.төг



2.3 Үнэ

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний үнийн индекс 2015 оны 6 дугаар сард өмнөх сарынхаас 0.1 хувиар буурч, өмнөх оны мөн үеэс 3,3 хувиар өслөө.

Хүснэгт1. Хэрэглээний үнийн индекс, 2015 оны 6 дугаар сар, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	ЖИН	2015-06	2015-06	2015-06	2015-06
		2010-12	2014-06	2014-12	2015-05
Ерөнхий индекс	100.0	165.8	103.3	102.5	99.9
Хүнсний бараа, ундаа, ус	36.0	174.2	99.1	104.9	99.8
Согтууруулах ундаа, тамхи	2.5	219.5	112.7	103.0	100.0
Хувцас, бөс бараа, гутал	18.0	216.9	106.2	101.5	100.0
Орон сууц, ус, цахилгаан, түлш	9.6	143.9	108.1	101.1	100.0
Гэр ахуйн тавилга, бараа	6.2	141.7	101.7	100.4	100.0
Эм тариа, эмнэлэгийн үйлчилгээ	1.6	121.0	103.7	100.0	97.8
Тээвэр	14.3	128.8	104.4	99.8	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	4.9	100.8	100.0	100.0	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	2.1	95.8	103.2	100.7	99.6
Боловсролын үйлчилгээ	0.2	268.5	159.9	100.0	100.0
Зочид буудал, зоогийн газар, дотуур байр	0.8	263.2	108.1	106.7	100.0

pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!

0.0




Ерөнхий индекс өмнөх сарынхаас 0,1 хувиар буурахад хүнсний бараа, ундаа, усны бүлэг 0,2 хувь, эм тариа, эмнэлгийн үйлчилгээ 2,2 хувь, амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээний бүлэг 0,4 хувь буурсан нь нөлөөлжээ.

Харин согтууруулах ундаа, холбооны хэрэгсэл, хувцас, бөс бараа, гутал, орон сууц, ус, цахилгаан, түлш, гэр ахуйн тавилга, бараа, тээвэр, шуудангийн үйлчилгээ, боловсролын бүлэг, зочид буудал, зоогийн газар, дотуур байр, бусад бараа үйлчилгээний бүлэг тогтвортой байна.


Хүснэгт. Хэрэглээний үнийн сарын индекст нөлөөлсөн бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлт

Бараа, үйлчилгээний бүлэг	Үнийн өөрчлөлт %	Дэд бүлэг, зарим барааны үнийн өөрчлөлт
Хүнсний бараа, ундаа, ус	-0.2	Энэ бүлгийн өсөлтөд мах, маханд бүтээгдэхүүн 0.3 хувь, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг 1.2, сахар жимсний чанамал, зөгийн бал, чихэр шоколад 0.2 хувь тус тус буурсан нь нөлөөлжээ.
Эм тарай, эмнэлгийн үйлчилгээ	-2.2	Эм тариа, эмнэлгийн хэрэгсэл 2.4 хувь буурсан нь нөлөөлсөн.
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	-0.4	Энэ бүлгийн өсөлтөд ном, сонин, бичиг хэрэгсэл 3.9 хувь буурсан нь нөлөөлөв.

Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2015 оны 6 дугаар сарын өөрчлөлт, бүлгээр, хувиар (өмнөх сар=100)



Зураг. Хэрэглээний үнийн индекс, 2013 - 2015 оны сар бүрээр
(өмнөх сар=100)



2.4 Хөдөө аж ахуй

Хагас жилийн байдлаар төллөвөл зохих эх малын 72.8 хувь буюу 525.1 мянган толгой мал төллөж, төл бойжилт 99.2 хувьтай байна. Энэ нь өмнөх оны мөн үеийнхээс 65.3 мянган толгой төлөөр буюу 14.2 хувиар олон мал төллөжээ.

2015 оны 6 сарын байдлаар 7807 толгой мал хорогдсон байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулж үзвэл 2.8 дахин олон мал хорогдсон байна. Өвчнөөр хорогдсон мал нийт хорогдлын 9.5 хувийг эзэлж байна. Нийт хорогдлын 82.7 хувь нь Мандах, Хөвсгөл, Хатанбулаг сумдад хорогдсон байна.



2.5 Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарт оны эхний 6 сард оны үнээр 5633.1 сая төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, 5180.1 сая төгрөгийн бүтээгдэхүүнийг зах зээлд борлууллаа. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт бүтээгдэхүүн 1.4 хувь, борлуулалт 32.1 хувиар буурсан байна. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалт буурахад уул уурхай олборлох салбарын бүтээгдэхүүн 22 дахин буурсан нь нөлөөлсөн байна.

Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2005 оны зэрэгцүүлэх үнээр 2030.0 сая төгрөг болж, өмнөх оноос 1.6 хувиар өссөн байна.

Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн 87.6 хувийг төрийн, 12.4 хувийг хувийн өмчийн аж ахуйн нэгжүүд үйлдвэрлэсэн байна.

Аж ахуйн нэгжийн хариуцлагын хэлбэрээр авч үзвэл улсын үйлдвэрийн газар 87.6 хувь, компани 6.5 хувь, хоршоо 0,5 хувь, өрхийн аж ахуй 5.4 хувийг тус тус үйлдвэрлэжээ.



53,2 тн-оор, нарийн боов 21,8 тн-оор, модон эдлэл 4841,0 мян.төгрөгөөр, хиам 0,6 тн-оор, эсгий эдлэл 82,1 мян.төгрөгөөр, савласан цэвэр ус 35,6 мян.литрээр, дээл 43-аар илүү үйлдвэрлэгджээ.



2.6.Тээвэр, Холбоо

Оны эхний 6 сарын байдлаар 23.2 мянган хүн зорчигч, 28.3 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс зорчигч 25.9 хувиар, тээсэн ачаа 24.8 хувиар буурчээ. Шуудан холбооны үйлчилгээний орлого 452.7 сая төгрөг болж өмнөх оноос 2 дахин өссөн байна. Суурин телефон цэгийн тоо 789 болж өмнөх оноос 2.0 хувиар буюу 16 хэрэглэгчээр буурчээ. 6 сарын байдлаар нийт 5.3 мянган ширхэг албан бичиг, захидал, 404 ширхэг илгээмж, илгээсэн бол шуудангаар 603 зорчигч үйлчлүүлж 11.3 сая төгрөгийн орлого оруулжээ.

Аймгийн хэмжээнд 6 кабелийн телевиз үйлчилгээ үзүүлж нийт 204.8 сая төгрөгийн орлого оруулж, 5250 байнгын хэрэглэгчдэд үйлчилж байна.

2015 оны 6 сарын байдлаар Дорноговь аймагт үүрэн телефоны оператор 4 компанийн салбар ажиллаж байгааг байршлаар авч үзвэл юнителын 15, мобикомын 14, скайтелын 13, G-mobile 12 нийт 61 салбар нэгж сум, суурин газруудад үйлчилгээ үзүүлж байна.



2.7 Барилга

2015 оны эхний 6 сарын байдлаар нийт 23,7 тэрбум төгрөгийн шинэ барилга, өргөтгөл, шинэчлэлт, их засварын ажил хийгдэж байна. Барилга угсралт их засварын ажлын хэмжээ өмнөх оны мөн үеэс 7,3 хувиар буурсан байна.

Барилга угсралт их засварын ажлын 43,5 хувь нь инженерийн барилга байгууламж, 31,7 хувь нь орон сууцны бус барилга, 24,2 хувь нь орон сууцны барилга, 0,6 хувь нь их засварын ажил эзлэж байна. Өмнөх оны мөн үеийнхээс орон сууцны барилга, орон сууцны бус барилгын эзлэх хувь 4,7-11,3 пунктээр буурч, инженерийн барилга, байгууламж, их засварын ажлын эзлэх хувь 17,8-1,8 пунктээр нэмэгдсэн байна.

_____ о О о _____



АГУУЛГА

I. Аймгийн эдийн засаг, нийгмийн зарим гол нэгдсэн үзүүлэлтүүд

II. Эдийн засаг, нийгмийн хөгжлийн байдлын тухай статистикийн тоон мэдээлэл
(Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

Нэг. Хөдөлмөр эрхлэлт

- 1.1 Ажил хайгч иргэдийн тоо, боловсролын түвшингээр
- 1.2 Ажил хайгч иргэдийн тоо, сумаар
- 1.3 Ажлын байрны захиалга, эдийн засгийн салбарын ангилалаар
- 1.4 Ажлын байрны захиалга ажил мэргэжлийн ангилалаар
- 1.5. Ажилд зуучилсан иргэд, ажил мэргэжлийн ангилалаар
- 1.6. Шинээр бий болгосон ажлын байр, эдийн засгийн салбарын ангилалаар

Хоёр. Нийгмийн даатгал, халамж

- 2.1 Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага, төрлөөр
- 2.2 Нийгмийн даатгалд заавал даатгуулагчийн тоо, олгосон тэтгэврийн хэмжээ
- 2.3 Нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдсан хүний тоо, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ

Гурав. Эрүүл мэнд

- 3.1 Эрүүл мэнд
- 3.2 Төрөлт, эх хүүхдийн эндэгдэл, сумаар
- 3.3 Халдварт өвчний гаргалт, сумаар

Дөрөв. Соёл

- 4.1 Соёлын үзүүлэлт

Тав. Байгаль орчин

- 5.1 Цаг уурын үзүүлэлт

Зургаа. Гэмт хэрэг

- 6.1 Бүртгэгдсэн хэргийн тоо төрлөөр, аймгийн дүнгээр
- 6.2 Бүртгэгдсэн хэргийн тоо сумаар

Долоо. Банк, зээл

- 7.1 Мөнгөн гүйлгээ, сая төгрөгөөр

Найм. Төрийн санхүү

- 8.1 Орон нутгийн төсвийн орлого, сая төгрөгөөр
- 8.2 Орон нутгийн төсвийн зарлага, сая төгрөгөөр
- 8.3 Орон нутгийн төсвийн орлого, зарлага, сумдаар, сая төгрөгөөр
- 8.4. Улсын нэгдсэн төсөвт төвлөрүүлсэн орлого, сая төгрөгөөр

Ес. Үнэ

- 9.1 Хэрэглээний үнийн индекс, 2015 оны 6 дугаар сард
- 9.2 Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ тариф
- 9.3 Гол нэрийн барааны үнэ, хөрш зэргэлдээ аймгуудаар

Арав. Хөдөө аж ахуй

- 10.1 Мал төллөлт, төл бойжилт
- 10.2 Том малын зүй бус хорогдол

Арван нэг. Аж үйлдвэр

- 11.1 Нийт бүтээгдэхүүн, 2005 оны зэрэгүүлэх үнээр, сая төг
- 11.2 Нийт бүтээгдэхүүн, борлуулалт, оны үнээр
- 11.3 Аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн жигд ажиллагаа
- 11.4 Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дэд салбараар
- 11.5 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, гол нэр төрлөөр
- 11.6 Бүтээгдэхүүний үйлдвэрлэл, сумаар, нийт бүтээгдэхүүн гол нэр төрлөөр

Арван хоёр. Тээвэр, холбоо, нефть

- 12.1. Шуудан, холбоо
- 12.2. Кабелийн телевиз
- 12.3 Телефон утасны сүлжээний байршил, 2015 оны 6-р сарын 30-ны байдлаар
- 12.4. Нефть хангамж

Арван гурав. Барилга

- 13.1 Барилга угсралт, их засварын ажил, жил бүрийн 6-р сард, сая төг

Тэмдэглэлийн тайлбар :

- (, ,) - тухайн тоо, баримт байхгүй
- (0) - тайлант хугацаанд гүйцэтгэлгүй
- (x) - энэ хүснэгтэнд тоо нөхөгдөхгүй
- (.) - мэдээлэгдэх хугацаа болоогүй

pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!



ДОРНОГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ
(2015 ОНЫ 06 ДУГААР САРЫН БАЙДЛААР)

I. Эдийн засаг, нийгмийн үндсэн үзүүлэлтүүд

	2011	2012	2013	2014	2015	2015 - 2014	$\frac{2015}{2014}$
1. Бэлэн хүн ам, мян.хүн *	60.5	60.9	62.5	63.5	63.8	0.3	100.5
- Төрсөн хүүхдийн тоо**	625	694	730	741	795	54	107.3
- Нас барсан хүний тоо - бодит тоогоор**	184	168	182	197	144	-53	73.1
- Хүн амын цэвэр өсөлт - бодит тоогоор	441	526	548	544	651	107	119.7
- Нялхасын эндэгдэл - бодит тоогоор	7	12	12	11	10	-1	90.9
- 1000 хүүхдэд ноогдох	11.2	17.3	16.4	14.8	12.6	-2.3	84.7
2. Ажилгүй иргэдийн тоо - бүгд	734	727	962	1151	1451	300	126.1
- Үүнээс эмэгтэй	490	452	527	715	833	118	116.5
- Хөдөлмөрийн насны 10000 хүнд ногдох ажилгүй иргэдийн тоо	198	181	239	281	355	73	126.06
3. Шинээр бий болсон ажлын байр-бүгд	476	441	601	683	353	-330	51.7
Үүнээс: Байнгын ажлын байр	282	244	295	547	353	-194	64.5
Улирлын чанартай ажлын байр	194	197	306	136	0	-136	0.0
4. Халдварт өвчний гаралт - бодит тоогоор	677	536	672	549	524	-25	95.4
- 10000 хүнд ногдох	112	88	108	87	83	-4	95.0
5. Гэмт хэргийн гаралт - бодит тоогоор	280	302	286	272	295	23	108.5
- 10000 хүнд ногдох ***	70	75	70	67	71	4	106.6
6.Бойжиж буй төл, толгойгоор	329545	352381	434982	459639	524952	65313	114.2
- Ботго	4871	4761	5144	5429	5669	240	104.4
- Унага	9921	9152	14191	16126	17733	1607	110.0
- Тугал	8213	9115	11620	13547	15869	2322	117.1
- Хурга	147966	166456	199843	215690	248813	33123	115.4
- Ишиг	158574	162897	204184	208847	236868	28021	113.4
7. Аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүн(сая.төг)	1801.7	1804.8	2190.8	5713.0	5633.1	-79.9	98.6
- Борлуулсан бүтээгдэхүүн (сая.төг)	2203.2	2524.9	2823.2	7627.8	5180.1	-2447.7	67.9

* - 2011, 2012, 2013, 2014 оны жилийн эцэст

**-Төрөлт, нас баралтыг ЭМГ-ын мэдээнээс авав.

*** - 18 - аас дээш насны 10000 хүнд ногдохоор тооцов.

pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!




II. ЭДИЙН ЗАСАГ НИЙГМИЙН ХӨГЖЛИЙН БАЙДЛЫН ТУХАЙ СТАТИСТИКИЙН ТООН МЭДЭЭЛЭЛ (Эдийн засгийн үйл ажиллагааны ангиллаар)

НЭГ. ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТ


1.1 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсролын түвшингээр

Боловсролын түвшингээр	2012.06	2013.06	2014.06	2015.06	$\frac{2015}{2012}$	$\frac{2015}{2014}$
Бүгд	727	962	1 151	1 451	199.6	126.1
Үүнээс: Эмэгтэй	452	527	715	833	184.3	116.5
Магистр, доктор	0	6	6	4	0.0	0.0
Дээд боловсролтой	191	215	356	389	203.7	109.3
Тусгай дунд	32	64	83	167	521.9	201.2
Техник мэргэжлийн	49	73	68	134	273.5	197.1
Бүрэн дунд	239	285	352	504	210.9	143.2
Бүрэн бус дунд	145	264	228	190	131.0	83.3
Бага	48	40	45	50	104.2	111.1
Боловсролгүй	23	15	13	13	56.5	100.0

ЗУРАГ. БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, боловсрол, хувиар 2015.06



ЗУРАГ. БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, хүйс, оноор



1.2 БҮРТГҮҮЛСЭН АЖИЛГҮЙ ИРГЭДИЙН ТОО, сумаар

	2014.06	2015.06	Ажилд орсон хүний тоо		Шинээр бүртгүүлсэн хүний тоо	
			2014.06	2015.06	2014.06	2015.06
Дүн	1151	1451	499	389	981	1280
Айраг	60	86	16	7	48	56
Алтанширээ	10	9	5	12	16	22
Даланжаргалан	39	58	4	7	36	53
Дэлгэрэх	25	26	29	14	47	32
Иххэт	13	17	13	4	21	24
Мандах	35	34	27	11	41	47
Өргөн	25	77	42	52	99	93
Сайхандулаан	26	25	20	28	25	45
Улаанбадрах	16	17	12	27	13	54
Хатанбулаг	34	49	25	10	54	38
Хөвсгөл	26	13	37	12	31	18
Эрдэнэ	18	17	22	12	20	28
Сайншанд	610	724	111	131	322	460
Замын - Үүд	214	299	136	62	208	310

1.4 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, ажил, мэргэжлийн ангилал 2015.06 сард

Үзүүлэлт	Бүгд
Бүгд	118
Менежир	1
Мэргэжилтэн	6
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	43
Контор, үйлчилгээний ажилтан	4
Худалдаа, үйлчилгээний ажилтан	0
ХАА, ой загас агнуурын ажилтан	6
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	5
Суурин төхөөрөмж, машин механизмын операторч, угсрагч	0
Энгийн ажил мэргэжил	53
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	0

1.3 АЖЛЫН БАЙРНЫ ЗАХИАЛГА, эдийн засгийн салбарын ангилал 2015.06 сард


Салбарын ангилал	Бүгд
Бүгд	118
ХАА, ойн аж ахуй,загас барилт, ан агнуур	6
Уул уурхай,олборлолт	0
Боловсруулах үйлдвэрлэл	27
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	1
Усны хангамж, бохир ус зайлуулах систем, хог хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	0
Барилга	0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар үйлчилгээ	0
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	0
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	4
Мэдээлэл, холбоо	0
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	0
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	6
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	4
Төрийн удирдлага, ба батлан хамгаалах, үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1
Боловсрол	4
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	7
Урлаг, үзвэр,тоглоом наадам	0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	58
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа,өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэсэн нэр төрлөөр нь салгаж тодорхойдох боломжгүй бүтээгдэхүүн, үйлчилгээ	0
Олон улсын байгууллага, суурин төлөөлөгчийн үйл ажиллагаа	0



1.5 АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, ажил, мэргэжлийн ангилалаар 2015.06 сард

Үзүүлэлт	Бүгд	эмэгтэй
Бүгд	389	213
Менежир	9	4
Мэргэжилтэн	57	43
Техникч болон туслах дэд/ мэргэжилтэн	47	35
Контор, үйлчилгээний ажилтан	21	14
Худалдаа, үйлчилгээний ажилтан	47	39
ХАА, ой загас агнуурын ажилтан	20	7
Үйлдвэрлэл, барилга, гар урлал, холбогдох ажил үйлчилгээний ажилтан	82	32
Суурин төхөөрөг, машин механизмын операторч, угсрагч	18	2
Энгийн ажил мэргэжил	83	37
Зэвсэгт хүчний ажил мэргэжил	5	0

Зураг. АЖИЛД ЗУУЧИЛСАН ИРГЭД, насны ангилал, хүйсээр 2015.06 сард



pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!

Зураг.ШИНЭЭР БИЙ БОЛСОН АЖЛЫН БАЙР,эдийн засгийн салбарын ангилалаар 2015.06 сард

Салбарын ангилал	Бүгд	Хүйсээр	
		Эм	Эр
Бүгд	353	193	160
ХАА, ан агнуур, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	15	5	10
Уул уурхай олборлолт	49	16	33
Боловсруулах үйлдвэрлэл	76	39	37
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	4	1	3
Барилга	27	8	19
Бөөний ба жижиглэн худалдаа,машин мотоциклийн засвар үйлчилгээ	65	36	29
Зочид буудал,байр, сууц болон хоол хүнсээр үйлчлэх үйл ажиллагаа	12	11	1
Тээвэр агуулахын аж ахуй, холбоо мэдээлэл	4	1	3
Санхүүгийн гүйлгээ хийх үйл ажиллагаа	0	0	0
Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	5	1	4
Захиргааны болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	13	11	2
Төрийн удирдлага, батлан хамгаалах үйл ажиллагаа албан журмын нийгмийн хамгаалал	23	20	3
Боловсрол	31	26	5
Хүний эрүүл мэнд ба нийгмийн халамжийн үйл ажиллагаа	5	4	1
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	23	13	10
Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа, өрхийн өөрийн хэрэглээнд зориулан үйлдвэрлэлэсэн хэмжээг нь тодорхойлох боломжгүй бүтээгдэхүүн үйлчилгээ	1	1	0

pdfMachine

Is a pdf writer that produces quality PDF files with ease!

Produce quality PDF files in seconds and preserve the integrity of your original documents. Compatible across nearly all Windows platforms, if you can print from a windows application you can use pdfMachine.

Get yours now!



ХОЁР. НИЙГМИЙН ДААТГАЛ

2.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА төрлөөр

	Олгосон тэтгэвэр тэтгэмж /сая төгрөг/		$\frac{2015}{2014}$
	2014.06	2015.06	
Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг	11 327.8	10 728.6	94.7
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	7 087.1	6 712.4	94.7
Тэтгэмжийн даатгалын сангийн	794.3	757.8	95.4
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2301	2 175.5	94.5
ҮОМШӨ-ний даатгалын сангийн	956.7	904.2	94.5
Ажилгүйдлийн даатгалын сангийн	188.7	178.7	94.7
Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг	12 951.1	14 987.5	115.7
Үүнээс: Тэтгэврийн даатгалын сангийн	9 149.1	11 462.9	125.3
Тэтгэмжийн даатгалын сангийн	849.7	929.0	109.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн	2 121.5	1 704.6	80.3
ҮОМШӨ**-ний даатгалын сангийн	684.0	673.8	98.5
Ажилгүйдлийн даатгалын сангийн	146.8	217.2	148.0

** - ҮОМШӨ- Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин

2.2 НИЙГМИЙН ДААТГАЛД ЗААВАЛ ДААТГУУЛАГЧДЫН ТОО, ОЛГОСОН ТЭТГЭВРИЙН

	2014.06	2015.06	$\frac{2015}{2014}$
1. Заавал даатгуулагч хүний тоо	14379	13842	96.3
Үүнээс: Аж ахуй нэгж, байгууллага	7587	6906	91.0
Төсөвт байгууллага	6792	6936	102.1
2. Олгосон тэтгэвэр, сая төг	8065.0	11697.7	145.0
Үүнээс: Өндөр насны тэтгэвэр	5643.9	8294.3	147.0
Хөгжлийн бэршээлтэй иргэдийн тэтгэвэр	842.3	1420.3	168.6
Тэжээгчээ алдсаны тэтгэвэр	472.7	620.5	131.3
ҮОМШӨ-ний даатгалын сангийн тэтгэвэр	440.8	442.8	100.5
Цэргийн тэтгэвэр	665.3	919.8	138.3

2.3 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮНИЙ ТОО,
ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ХЭМЖЭЭ, төрлөөр

	Хамрагдсан хүний тоо		2015 2014	Олгосон тэтгэвэр тэтгэмж /мян төгрөг/		2015 2014
	2014.06	2015.06		2014.06	2015.06	
1. Халамжийн тэтгэвэр	1,269	1,189	93.7	854,887.5	875,201.4	102.4
2. Нөхцөлт мөнгөн тэтгэмж: Үүнээс	7,134	7,123	99.8	1,289,836.6	1,286,344.2	99.7
Жирэмсэн болон нярай, хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн тэтгэмж	1766	1720	97.4	397,998.7	365,012.9	91.7
Ахмад настныг асарч буй иргэнд	370	428	115.7	122,082.1	138,621.6	113.5
Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг асарч буй иргэнд	250	280	112.0	79,647.7	93,396.5	117.3
Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг асарч буй иргэнд	162	170	104.9	48,219.6	57,425.4	119.1
Бүтэн өнчин хүүхэд асран хамгаалж үрчлэн авч өсгөсний тэтгэмж	35	40	114.3	11,296.5	14,389.8	127.4
Гэр бүлийн тухай хуулийн 25.5-д заасан хүүхдийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа иргэнд	10	5	50.0	2,856.8	1,030.3	36.1
Ганц бие ахмад настныг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа иргэнд	5	7	140.0	1,318.4	1,864.7	141.4
Ганц бие хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асран хамгаалж байгаа иргэнд	7	8	114.3	2,476.8	2,463.0	99.4
Алдарт эхийн одонтой эхчүүдэд олгосон тусламж	4529	4465	98.6	623,940.0	612,140.0	98.1
3. Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт: Үүнээс	3,482	3,532	101.4	364,583.3	410,278.6	112.5
Ахмад настнуудад үзүүлсэн 1 удаагийн хөнгөлөлт, тусламж	2,398	2,405	100.3	78,860.3	113,561.8	144.0
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн тусламж, хөнгөлөлт	168	133	79.2	47,924.0	52,610.8	109.8
Нийгмийн халамжийн дэмжлэг, мөнгөн тэтгэмж	894	975	109.1	215,282.2	225,006.0	104.5
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	22	19	86.4	22,516.8	19,100.0	84.8
Хүний хөгжил сангийн хишиг	0	0	0.0	0.0	0.0	0.0



ГУРАВ. ЭРҮҮЛ МЭНД

3.1 ЭРҮҮЛ МЭНД

	Хэмжих нэгж	2014.06	2015.06	Өсөлт	
				Тоо	Хувь
1. Амбулаторийн үзлэг	мян.хүн	217.5	199.4	-18.1	91.7
2. Ор хоног	мян.хүн	51.0	51.4	0.4	100.8
3. Урьдчилан сэргийлэх тарилга	мян.хүн	6.0	6.1	0.1	101.7
4. Эмчлүүлсэн хүний тоо	мян.хүн	7.3	7.2	-0.1	98.6
5. Түргэн тусламжын дуудлага	мян.хүн	11.5	9.8	-1.7	85.2
Үүнээс: алсын дуудлага	мян.хүн	1.9	1.6	-0.3	84.2
6. Осол гэмтлийн өвчлөл	хүн	1091	1297	206	118.9
Үүнээс: нас баралт	хүн	56	35	-21	62.5
7. Шинээр хяналтанд авсан жирэмсэн эх	хүн	949	859	-90	90.5
Үүнээс: эхний 3 сартайн хяналт	хүн	820	715	-105	87.2
8. Амаржсан эх	хүн	737	785	48	106.5
Үүнээс: нас баралт	хүн	0	0	0	
9. 1-5 хүртэл насны эндсэн хүүхэд	хүн	8	0	-8	0.0
10. 1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	хүн	11	10	-1	90.9

3.2. ТӨРӨЛТ, ЭХ, ХҮҮХДИЙН ЭНДЭГДЭЛ, сумаар. 2015.06-р сард

Сум	Амаржсан эх	Эхийн эндэгдэл	Амьд төрсөн хүүхэд	1 хүртэл насандаа эндсэн хүүхэд	1-5 хүртэл насны эндсэн хүүхэд
Дүн	785	0	795	10	0
Айраг	1		1		
Алтанширээ	1		1		
Даланжаргалан	2		2		
Дэлгэрэх	4		4		
Иххэт	1		1		
Мандах	0		0		
Өргөн	1		1		
Сайхандулаан	0		0		
Улаанбадрах	0		0		
Хатанбулаг	1		1		
Хөвсгөл	0		0		
Эрдэнэ	0		0		
Сайншанд	661		671	8	
Замын - Үүд	113		113	2	
